Монголын уламжлалт анагаах ухааны хэвлэн нийтэлсэн нэр томъёонд дүн шинжилгээ хийх нь

Гэрэлцогт[1], Б.Амар-Амгалан[1], Э.Бямбаа[1], Б.Дааримаа[1], Ө.Түмэнцэцэг[1], Б.Цэрэнчимэд[1], Ө.Энхсайхан[1], Б.Дагвацэрэн[2], Б.Цэрэнцоо[2]

[1]АШУҮИС, МАУОУС
[2]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт Жор Судлалын Тэнхим
Цахим шуудан: tserentsoo@mnums.edu.mn, Утас: 99242596

Түлхүүр үг:

Уламжлалт анагаах ухааны нэр томъёо Үгсийн сангийн зэрэгцүүлэл

Товч утга:

Үндэслэл: Нийгмийн хөгжлийн явцад хэл ямагт боловсронгуй болдог бөгөөд үгүй бол хүний харилцааны хэрэглүүр болох нийгмийн үүргээ биелүүлж чадахгүйд хүрнэ. Хүний мэдлэгийн хүрээ тэлэх тусам шинэ нэр томьёо үүснэ. Аливаа судалгааны чиглэл, салбар шинжлэх ухаанд нэр томъёо судлал чухал байр суурийг эзэлдэг бөгөөд уламжлалт анагаах ухааны нэр томъёо тэдгээрийг судлан тогтоох, түүвэрлэх, тайлбарлах, олон улсад хүлээн зөвшөөрөгддөг нэр томъёонд дүйцүүлэн хөрвүүлэх нь тулгамдсан асуудал юм. Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр хэвлэгдэн нийтлэгдэж буй сэтгүүлүүдийн нэр томъёоны зөрүүтэй байдалд дүн шинжилгээ хийж, харьцуулан судалж, нэр томъёог жигдлэх ажлын үндэс суурь болгох үүднээс энэхүү судалгааны сэдвийг сонгон авлаа. **Зорилго:** Монголын уламжлалт анагаах ухааны хэвлэн нийтлэгдсэн нэр томъёонд дүн шинжлэл хийж харьцуулан судлах. **Арга, аргачлал:** Уг судалгааны ажлыг АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль болон ӨМӨЗО-ны Хөх хотын Олон Улсын Монгол Эмнэлгийн хорооны сургалт судалгааны хэлтэсийг түшиглэн хийж гүйцэтгэв. МАУОУС-иас эрхлэн гаргадаг “Шинжлэх Ухаан танин мэдэхүйн дорно дахины уламжлалт анагаах ухаан” сэтгүүл, ӨМӨЗО-ны Эрүүлийн хамгаалах танхим, Монгол эм эмнэлэг судлах хүрээлэн, Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн хорооноос эрхлэн гаргадаг “Монгол эм эмнэлэг” нь монгол анагаах ухааны тусгай дугаар бүхий сэтгүүл бөгөөд эдгээр сэтгүүлүүдийг судалгааны гол хэрэглэгдэхүүн болгон сонгон авлаа. **Үр дүн:** Монгол эм эмнэлэг сэтгүүлийн 2008-2014 оны судалгааны өгүүлэлд нийт 1577 судалгаа байв. Эмийн жор найрлагын судалгаа 217 (13.7%) Эмийн түүхий эдийн судалгаа 55 (3.48%) Эм найрлагын судалгаа 83 (5.26%) Монгол эмийн судалгаа 170(10,77%) Онолын судалгаа 113 (7.16) Эмэгтэйчүүдийн өвчний эмчилгээний судалгаа 70 (4.43%) Засал эмчилгээ 97(6,15%) Өвчний сувилал, сувилахуйн судалгаа 95(6%) Үе гишүүний өвчний эмчилгээний судалгаа 76 (4.8%)-г эзэлж байна. МУАУ-ны нэр томъёонд мэргэжлийн үгийн сангийн хэрэглээний зэрэгцүүлэл хийж харьцуулахад цэвэршилтийн хам шинжийг хугацааны өвчин, умайн хүзүүний шархлаат өвчинг савны хүзүүний ялбарал, зуршмал зулбалтыг дадгалын чанартай ураг унах гэм, үргүйдлийг ирээдүйн үл жирэмслэх өвчин зэрэг нэр томъёогоор нэрлэсэн нь өөрийн онцлогтой байна. Мөн бүсэлхий нурууны ивэрхий (lumbar herniated intervertebral disc)-г бүсэлхий нурууны үеийн таваг товойсон гэм хэмээн нэрлэсэн байна. **Дүгнэлт:** МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн онол, эмчилгээ, оношилгооны арга, өвчний оношлогоо болон эмийн түүхий эдийн нэр томьёонд дүн шинжилгээ хийж, уламжлалт анагаах ухааны нэр томьёонд үгийн сангийн хэрэглээний зэрэгцүүлэл хийхэд Монголын уламжлалт анагаах ухааны өвчний онол, оношлогоо, эмчилгээний арга нь өөрийн онцлог бүхий нэр томъёотой байв. Ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эдийн нэр томьёо нь эмийн жорын найрлагад төвд нэршилээр бичигддэг, зарим эмийн түүхий эдийг орлуулан хэрэглэдэг зэргээс шалтгаалан нэлээд зөрүүтэй бичигдсэн байдаг нь эмийн жор найрлагад орсон түүхий эдийг зөв сонгож хэрэглэхэд бэрхшээл болдог байна.

Үндэслэл: Нийгмийн хөгжлийн явцад хэл ямагт боловсронгуй болдог бөгөөд үгүй бол хүний харилцааны хэрэглүүр болох нийгмийн үүргээ биелүүлж чадахгүйд хүрнэ. Хүний мэдлэгийн хүрээ тэлэх тусам шинэ нэр томьёо үүснэ. Соёл урлаг, шинжлэх ухаан, техник эдийн засаг зэрэг тодорхой салбарын ухагдахуун үйл ажиллагааг тусгайлан оноож нэрлэсэн үгсийг нэр томьёо гэнэ. Нэр томьёог өөрийн хэлний, харийн хэлний гэж хуваан үздэг. Язгуурын монгол үгээр оноосон монгол нэр томьёо өмнө ч олон байсан одоо ч байсаар байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд нэр томьёо оноон тогтоох, журамлан жигдлэх төрийн тууштай бодлого алдагдсанаас харийн нэр томьёо хүч түрэн орж ирэх болжээ.[1]

Анагаах ухаанд латин нэр томъёог хэрэглэх арга зүйг анх Цельс Корпелит (МЭӨ 1), Гален Клавдин (МЭӨ 2) нар санаачилан, Гиппократ (МЭӨ 4), тэдний энэ санаачлагыг боловсронгуй болгож хөгжүүлсэн байна. Латин хэлний ачаар анагаах ухааны нэр томъёо олон улсын шинж чанартай болж, эмч мэргэд нар өөр хоорондоо түвэггүй ойлголцдог болжээ. Тиймээс учраас «латин хэлний Мэдлэггүй аваас анагаах ухаанд нэвтрэх зам хаалттай» хэмээн тэмдэглэсэн сургаалыг эмч хүн мартах учиргүй[2].

Монголчууд нэр томьёог орчуулан хэрэглэж ирсэн эртний уламжлалтай ард түмэн бөгөөд 1921 оноос Улсын нэр томьёоны комиссыг байгуулан монгол хэлнээ орж ирсэн гадаад нэр томьёог орчуулан салбар бүрээр 147 орчим цуврал бүтээлүүдийг хэвлэсэн байдаг.

Аливаа судалгааны чиглэл, салбар шинжлэх ухаанд нэр томъёо судлал ухал байр суурийг эзэлдэг бөгөөд уламжлалт анагаах ухааны нэр томъёо тэдгээрийг судлан тогтоох, түүвэрлэх, тайлбарлах, олон улсад хүлээн зөвшөөрөгдөөр нэр томъёонд дүйцүүлэн хөрвүүлэх нь тулгамдсан асуудал юм. Монголын уламжлалт анагаах ухааны нэр томъёо, үг хэллэгийн 5000 үгтэй толь бичгийг УАУ-ны салбарын эрдэмтэд боловсруулан хэвлүүлжээ[3,4].

Монгол улсын Уламжлалт анагаах ухааны төрийн бодлого - Уламжлалт эмийн үйлдвэрлэл, эмийн ургамал, эм танг олон улсад зөвшөөрөгдөхүйц чанар, стандартыг хангасан байх зэрэг шаардлагад үндэслэн Уламжлалт эмийн үйлдвэрт түгээмэл хэрэглэгддэг эмийн түүхий эдийн нэр томьёоны толь боловсруулах ажлын хэсэг ЭМЯ-ы Сайдын 2018 оны 06 сарын 04 ний өдрийн А/220 дугаар тушаалаар батлагдан ажиллажээ. УАУ-д хэрэглэгддэг ургамлын гаралтай түүхий эдийн нэршлийн зөрүүтэй байдал”-ын талаар хэлэлцэж, “МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ НЭГДМЭЛ БАЙДАЛ: Эмийн түүхий эдийн нэршил” нээлттэй хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж гаргасан байна[5].

Монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр хэвлэгдэн нийтлэгдэж буй сэтгүүлүүдийн нэр томъёоны зөрүүтэй байдалд дүн шинжилгээ хийж, харьцуулан судалж, нэр томъёог жигдлэх ажлын үндэс суурь болгох үүднээс энэхүү судалгааны сэдвийг сонгон авлаа.

Зорилго: Монголын уламжлалт анагаах ухааны хэвлэн нийтлэгдсэн нэр томъёонд дүн шинжлэл хийж харьцуулан судлах нь

Зорилт:

1. МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн оношийн нэр томъёонд дүн шинжилгээ хийж, харьцуулан судлаж, онцлогийг тодруулах
2. МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн эмийн түүхий эдийн нэр томьёонд дүн шинжилгээ хийж, харьцуулан судлаж, онцлогийг тодруулах

Арга, аргачлал:

Судалгааны загвар: Энэхүү судалгааг баримтын судалгааны аргаар хийв. Баримтын арга нь судалгаатай холбоотой тулгуур бүтээлийг харьцуулан судлах зүйлийнхээ талаар өргөн дэлгэр ойлголттой болж, эрэмбэ дараатайгаар хооронд нь харьцуулах, жиших, олон жилийн турш хуримтлагдсан, түүхий материалдаа тодорхой зорилготой, системтэйгээр шинжилгээ, үнэлгээ хийж, онолын судалгааны дүгнэлт хийлээ.[10,11]

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн: МАУОУС-иас эрхлэн гаргадаг “Шинжлэх ухаан танин мэдэхүйн дорно дахины уламжлалт анагаах ухаан» сэтгүүл, ӨМӨЗО-ны Эрүүлийн хамгаалах танхим, Монгол эм эмнэлэг судлах хүрээлэн, Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн хорооноос эрхлэн гаргадаг “Монгол эм эмнэлэг” нь Өвөр монголд байгаа цорын ганц монгол анагаах ухааны тусгай дугаар бүхий сэтгүүл бөгөөд эдгээр сэтгүүлүүдийг судалгааны гол хэрэглэгдэхүүн болгон сонгон авлаа.

“Шинжлэх Ухаан танин мэдэхүйн дорно дахины уламжлалт анагаах ухаан” (ISSN 2309-5687) сэтгүүл нь 2011 оноос-2019 оны 4 сар хүртэл 17 нийт дугаар хэвлэгдэн гарсан бөгөөд судалгааны 221 өгүүлэл, 109 илтгэлийг нийтэлж судалгааны эргэлтэд оруулжээ[8]. “Дорно дахины уламжлалт ангаах ухааны сэтгүүл”, УАЭСН-ийн “Монголын уламжлалт анагаах ухаан” сэтгүүлүүд нь нэгдэж, ”Нэгтгэмэл анагаах ухааны монголын сэтгүүл” (ISSN2664-3456) нэртэйгээр хэвлэгдэн гарч байна.

“Монгол эм эмнэлэг” сэтгүүл бол монгол анагаах ухааны тусгай дугаар бүхий сэтгүүл юм[9]. Тус сэтгүүл нь анх 1974 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд дотооддоо тараагдаж байгаад 1987 оноос эхлэн улсын дотоод, гадаадад гаргадаг болжээ. Анх 1 жилд 4 дугаар, дугаар бүр 48 нүүр байсан бөгөөд 2008 оноос 1 жилд 6 дугаар, дугаар бүр 80 нүүртэй болжээ. Өдгөө жилд 12 дугаар хэвлэгдэж дугаар бүр 112 хуудастай болон хөгжиж ирсэн. Тус сэтгүүлд голлон өвөр монголын эрдэмтдийн бүтээлүүд ирэхээс гадна Хар мөрөн, Гирин, Ляо Нин, Хөх нуур, Шиньжян, Гань Сү, Бээжин зэрэг 8 газар орны монгол анагаах ухааны багш, эмч, эм бариач, сувилагч, эрдэм шинжилгээний ажилтан зэргээс эрдэм шинжилгээний бүтээлээ ирүүлдэг байна. Хэвлэх өгүүллийг агуулгаар нь үндэслэн дугаар бүрт онол, түүх, сурвалж бичгийн булан, заах аргын булан, ахмад эмчийн туршлагын булан, туршлага солилцооны булан, гадар заслын булан, эм жорын булан, сувилалтын булан, аспирантын булангуудад

хуваан нийтэлдэг.

Монгол эм эмнэлэг сэтгүүлд хэвлэн нийтлэгдсэн өгүүллийн гарчиг болон түлхүүр үгийг задлан, харьцуулсан судалгааны үр дүн: Монгол эм эмнэлэг сэтгүүлийн 2008-2014 оны судалгааны өгүүлэлд нийт 1577 судалгаа байв. Эмийн жор найрлагын судалгаа 217 (13.7%) Эмийн түүхий эдийн судалгаа 55 (3.48%) Эм найрлагын судалгаа 83 (5.26%) Монгол эмийн судалгаа 170(10,77%) Онолын судалгаа 113 (7.16) Эмэгтэйчүүдийн өвчний эмчилгээний судалгаа 70 (4,43%) Засал эмчилгээ 97 (6.15%) Өвчний сувилал, сувилахуйн судалгаа 95(6%) Үе гишүүний өвчний эмчилгээний судалгаа 76 (4.8%)-г эзэлж байна. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Монгол эм эмнэлэг сэтгүүлд хэвлэн нийтлэгдсэн өгүүллийн гарчиг болон түлхүүр үгийг харьцуулан, онол, эмчилгээ, засал, эм найрлагаар задлан түүвэрлэсэн судалгааны үр дүн

№	Ангилал	Тоо	Хувь
1	Жор	217	13.7%
2	Эмийн түүхий эд	55	3.48%
3	Эм найруулах	83	5.26%
4	Монгол эм	170	10.77%
5	Онол	113	7.16%
6	Засал	97	6.15%
7	Өвчний сувилалалт	95	6%
8	Үе гишүүн	76	4.8%
9	Эмэгтэйчүүдийн өвчин	70	4.43%
10	Идээ ундаа	50	3.17%

МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн онол, эмчилгээ, оношилгооны арга, өвчний онош болон эмийн түүхий эдийн нэр томьёонд дүн шинжилгээ хийж, харьцуулан судалж, түүний онцлогийг тодруулж, Уламжлалт анагаах ухааны нэр томьёог харьцуулсан судалгааны үр дүн: МУАУ-ны нэр томъёонд мэргэжлийн үгийн сангийн хэрэглээний зэрэгцүүлэл хийж харьцуулахад цэвэршилтийн хам шинжийг хугацааны өвчин, умайн хүзүүний шархлаат өвчинг савны хүзүүний ялбарал, зуршмал зулбалтыг дадгалын чанартай ураг унах гэм, үргүйдлийг ирээдүйн үл жирэмслэх өвчин зэрэг нэр томъёогоор нэрлэсэн нь өөрийн онцлогтой байна. Мөн бүсэлхий нурууны ивэрхий (lumbar herniated intervertebral disc)-г бүсэлхий нурууны үеийн таваг товойсон гэм хэмээн нэрлэсэн байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн оношийн нэр томьёонд дүн шинжилгээ хийж, түүний онцлогийг тодруулж, харьцуулсан судалгааны үр дүн

№	МУАУ-ны нэр томъёо	ОУАУ-ны нэр томъёо
1	Хугацааны өвчин	Цэвэршилтийн хам шинж
2	Сарын хирийн эвэршээл	Бие юм өвдөлттэй ирэх
3	Ирээдүйн үл жирэмслэх өвчин	Үргүйдэл
4	Савны хүзүүний ялбарал	Умайн хүзүүний шархлаат өвчин
5	Дадгалын чанартай ураг унах	Зуршмал зулбалт
6	Бүсэлхий нурууны үеийн таваг товойсон гэм	Бүсэлхий нурууны ивэрхий (lumbar herniated intervertebral disc)

МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн эмийн түүхий эдийн нэр томьёонд дүн шинжилгээ хийж, түүний онцлогийг тодруулж, харьцуулсан судалгааны үр дүн: Монгол эм эмнэлэг сэтгүүлд хэвлэдгсэн нэр томъёонд судалгаа хийж үзэхэд дан жорын үйлдэлийн судалгаа болон хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, зүрх судасны эрхтэн тогтолцооны талаарх судалгааны ажил илүү бичигдсэн байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн эмийн жор эмийн түүхий эдийн нэр томьёонд дүн шинжилгээ хийж, түүний онцлогийг тодруулж, харьцуулсан судалгааны үр дүн

Эрхтэн тогтолцоо	Тоо	Хувь
Хоол боловсруулах эрхтэн тогтолцоо	35	16.2%
Амьсгал эрхтэн тогтолцоо	2	0.92%
Зүрх судас эрхтэн тогтолцоо	23	10.5%
Дотоод шүүрэл	15	6.9%
Шээс ялгаруулах эрхтэн тогтолцоо	5	2.3%
Араг яс эрхтэн тогтолцоо	6	2.76%
Мэдрэл эрхтэн тогтолцоо	10	4.6%
Арьс харшил	20	9.2%
Дан тан үйлдэл	56	25.8%
Нийт	217	100%

Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэж ирсэн ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эдийн нэр томьёо нь эмийн жорын найрлагад төвд нэршилээр бичигддэг, зарим эмийн түүхий эдийг орлуулан хэрэглэдэг зэргээс шалтгаалан нэлээд зөрүүтэй бичигдсэн байдаг нь эмийн жор найрлагад орсон түүхий эдийг зөв сонгож хэрэглэхэд бэрхшээл болдог. Тухайлбал: Жүр үр 3 янзын жүр үр байхаар тэмдэглэсэн байна. Монгол оронд жүр үрийн оронд долоогоно жимсээр орлуулан хэрэглэдэг байсан байна. Монгол оронд 80 гаруй хунчир байдаг, Хунчирын өөр төрлийг “сардма” гэдэг. Мөн ургамлыг ёгт нэр, санскрит нэршил, нутгийн нэршилээр нэрлэсэн, олдоц муутай ховор эмийн ургамлыг өөрийн оронд ургадаг ижил амт, эрдэмтэй эмийн ургамлаар орлуулан

хэрэглэдэг зэргээс тухайн жоронд орж буй эмийн ургамал, эмийн түүхий эд андуурдах тохиодол их гардаг байна. Тиймд нэршил дээр төвөд эх сурвалжаас тодруулан харьцуулах зайлшгүй шаардлага тулгарч байв.

Хэлцэмж: Хүний мэдлэгийн хүрээ тэлэх тусам шинэ нэр томьёо үүснэ. Соёл урлаг, шинжлэх ухаан, техник эдийн засаг зэрэг тодорхой салбарын ухагдахуун үйл ажиллагааг тусгайлан оноож нэрлэсэн үгсийг нэр томьёо гэнэ. Нэр томьёог өөрийн хэлний, харийн хэлний гэж хуваан үздэг. Язгуурын монгол үгээр оноосон монгол нэр томьёо өмнө ч олон байсан одоо ч байсаар байна. Гэсэн хэдий ч сүүлийн жилүүдэд нэр томьёо оноон тогтоох, журамлан жигдлэх төрийн тууштай бодлого алдагдсанаас харийн нэр томьёо хүч түрэн орж ирэх болжээ. Харийн нэр томьёог хэт нутагшуулах нь эх хэлний дархлаанд сөрөг нөлөөтэй тул аль болох өөрийн хэлний үгийн нөөцийг шавхаж нэр томьёог оноон нэрлэж, жигдлэн толилж байхыг эрхэмлэх нь зүйд нийцнэ. Аливаа нэр томьёо тогтвортой хэрэглэгдэж нийтийн хэрэгцээт үг хэллэг болж хэвших нь тухайн үгээр тэмдэглэгдсэн зүйлийн хэрэглээнээс хамаарах төдийгүй тухайн үг ухагдахуунаа хэр оновчтой илэрхийлж байгаатай холбоотой байдаг[1].

Монголчууд нэр томьёог орчуулан хэрэглэж ирсэн эртний уламжлалтай ард түмэн бөгөөд 1921 оноос Улсын нэр томьёоны комиссыг байгуулан монгол хэлнээ орж ирсэн гадаад нэр томьёог орчуулан салбар бүрээр 147 орчим цуврал бүтээлүүдийг хэвлэсэн байдаг. Эдгээр бүтээлийн ихэнх хувь нь орос хэлнээс монгол хэлнээ өргөн хэрэглэгдэж байсан нэр томьёо орчуулга голчилдог аж. Харин 1991 оноос өнөөг хүртэл орчуулсан бүтээлд англи болон бусад хэлний нэр томьёоны орчуулга голлож шинжлэх ухааны салбар бүрээр нэр томьёоны орчуулгын бүтээлүүд мэр сэр хэвлэгдэн гарч олны хүртээл болж байна.

Сонин нийтлэл, хэвлэл мэдээллийн хэл найруулгад түгээмэл хэрэглэгдэж буй нэр томьёоны бүрэлдэхүүнийг ажиглавал, тухайн нийлмэл нэр томьёоны аль нэг бүрдүүлбэр нь эсвэл хоёул урьд өмнө нь хэрэглэгдэж байсан үгийг зохион найруулж нийлмэл шинэ нэр томьёо бүтээх үзэгдэл түгээмэл болж байна.

Шинжлэх ухаан салбарт нэр томьёоны онолын талаар нарийвчлан ойлголт авахаар бүтээл цөөн байхын дээр нэр томьёоны ухагдахуун, тодорхойлолт, нэр томьёо үг хоёрын хоорондын зааг ялгааг тогтоосон мөн нэр томьёог орчуулахад баримтлах зарчмыг тайлбарласан монгол хэлээрх бүтээл тун ховор билээ[10,11].

Нэр томьёоны орчуулга судлал бүтээлд нэр томьёог оноон нэрлэх, орчуулах, нийгэм хүмүүнлэг, байгалийн ухаан, техник технологийн нэр томьёоны орчуулгын тухай, Монголчуудын нэр томьёог орчуулж ирсэн үүх түүх, төрөл утгат болон харьяа утгат нэр томьёог хэрхэн орчуулах, ойролцоо болон олон утгат нэр томьёо, бодот болон хийсвэр утгат нэр томьёог ч нарийн ангилан арга зарчим, онолд тулгуурлан нэр томьёог орчуулахдаа ямар зарчим баримтлах, тухайлбал шууд хуулбарлах, утгачлах, буулгах, зээлдэх, тайлбарлан орчуулах зэрэг олон арга барил, гадаад үгийг галигчлан болон үсэгчлэн хөрвүүлэх тогтолцоотой дүрэм боловсруулж мөрдөх, нэр томьёог хэрхэн галигчлан, үсэгчлэн хөрвүүлэх талаар авиа, үсэг тус бүрээр авч үзэн дүрэм боловсруулж, энэхүү бүтээлдээ хавсаргажээ[3].

Монголын уламжлалт анагаах ухааны нэр томъёо, үг хэллэгийн 5000 үгтэй толь бичгийг УАУ-ны салбарын эрдэмтэд боловсруулан хэвлүүлжээ[4].

УАУ-д хэрэглэгддэг ургамлын гаралтай түүхий эдийн нэршлийн зөрүүтэй байдал"-ын талаар хэлэлцэж, "МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ НЭР ТОМЬЁОНЫ НЭГДМЭЛ БАЙДАЛ: Эмийн түүхий эдийн нэршил" нээлттэй хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж гаргасан байна[5].

МАУОУС-ийн эрдэмтэд "Шинжлэх Ухаан танин мэдэхүйн дорно дахины уламжлалт анагаах ухаан» (ISSN 2309-5687) сэтгүүлийг эрхлэн гаргадаг бөгөөд судалгааны 221 өгүүлэл, 109 илтгэлийг нийтэлж судалгааны эргэлтэд оруулсан. Уг сэтгүүл нь уламжлалт анагаах ухааны чиглэлээр ажиллаж байгаа эмч мэргэжилтэн, магистр, доктор оюутнуудын судалгааны материалаа хэвлүүлэх таатай боломжийг бүрдүүлж өгсөн байна.[8]

ӨМӨЗО-ны "Монгол эм эмнэлэг" сэтгүүл бол монгол анагаах ухааны тусгай дугаар бүхий сэтгүүл юм. Тус сэтгүүл нь анх 1974 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд анх 1 жилд 4 дугаар, дугаар бүр 48 нүүр байсан бөгөөд 2008 оноос 1 жилд 6 дугаар, дугаар бүр 80 нүүртэй болжээ. Өдгөө жилд 12 дугаар хэвлэгдэж дугаар бүр 112 хуудастай болон хөгжиж иржээ.[9]

Өнөөгийн монголын уламжлалт анагаах бүрэлдэн бий болж хөгжихөд өөр бусад орны анагаах ухааны нөлөөллийг системтэйгээр судлан тогтооход дараах арга, аргачлалыг баримталж байгаа бөгөөд бид барууны судлаачдын баримталж байгаа эх бичиг, сурвалж бичгийг нягтлан шинжлэх чанарын судалгааны аргыг (quality analysis method) судалгаандаа өргөн ашиглахаар боловсруулаа[10].

Анализ синтезийн аргаар судалгааны эх хэрэглэгдэхүүн болох эх сурвалжуудын бүлэг бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдэд задлан ангилж, түүнийг ижил төстэй агуулгаар нь харьцуулан судалдаг[11]. Энэхүү аргыг нарийвчлан задалвал: Уг зохиолыг бичихэд хэрэглэсэн эх сурвалжуудыг сэдвээр бүлэглэх аргачлалын (theme analysis) дагуу кодлон ангилсны үндсэн дээр хамгийн олноор давтагдах кодуудыг бүлэглэх замаар голлох эх сурвалжуудыг тодорхойлдог. Бичиглэлд дүн шинжилгээ хийх аргын (textual analysis) дагуу зохиогчийн зүгээс илэрхийлсэн үзэл баримтлалыг судалдаг бөгөөд бид судалгаандаа энэхүү аргыг ашиглав.[12-23]

Дүгнэлт:

1. МУАУ-ны хэвлэгдэн нийтлэгдсэн онол, эмчилгээ, оношилгооны арга, өвчний онош болон эмийн түүхий эдийн нэр томьёонд дүн шинжилгээ хийж, түүний онцлогийг тодруулж, уламжлалт анагаах ухааны нэр томьёонд үгийн сангийн хэрэглээний зэрэгцүүлэл хийхэд нутаг орны онцлогтой байв.
2. Монголын уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэж

ирсэн ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийн түүхий эдийн нэр томьёо нь эмийн жорын найрлагад төвд нэршилээр бичигддэг, зарим эмийн түүхий эдийг орлуулан хэрэглэдэг зэргээс шалтгаалан нэлээд зөрүүтэй бичигдсэн байдаг нь эмийн жор найрлагад орсон түүхий эдийг зөв сонгож хэрэглэхэд бэрхшээл болдог байна.

Ном зүй:

1. *Соёмбо нэвтэрхий толь «Хэл шинжлэл», УБ 2017*
2. *Монгол судлалын хүрээлэн «Нийтээр эзэмших монгол хэл», УБ 2017*
3. *Н.Мөнхцэцэг. "Нэр томьёоны орчуулга судлал"*
4. *Монголын уламжлалт анагаах ухааны нэр томъёо, үг хэллэгийн толь бичиг. Улаанбаатар. 2011*
5. *ЭМЯ-ы Сайдын 2018 оны 06 сарын 04 ний өдрийн А/220 дугаар тушаал*
6. *Ичинхорлоо.Ш Диссертацийн ажлын арга судлалын үндэс 2011 он. УБ. 53х*
7. *Нарантуяа.Д Чанарын аргын судалгаа 2012 он. УБ. Эдмон. 24х*
8. *Нэгтгэмэл анагаах ухааны Монголын сэтгүүл. Улаанбаатар. 2019-2021*
9. *Монгол эм эмнэлэг сэтгүүл. ӨМӨЗО. Хөх хот.*
10. *Батсайхан Н. Монгол уламжлалт анагаах ухаан: Зарим эх сурвалжийн нягтлан шинжлэл. Улаанбаатар:Ном Хур принтинг.2021.*
11. *Нансалмаа.Н Хэлшинжлэлийн судалгааны арга зүй 2014 он УБ. Соёмбо принтинг хэвлэлийн газар. 17, 19х*
12. *Boyatzis, Richard (1998). Transforming qualitative information: Thematic analysis and code development. Thousand Oaks, CA: Sage.*
13. *Lasswell, Harold Dwight (1948). Power and personality. New York, NY.*
14. *Ванчигсүрэн.Д нар Судалгаа шинжилгээний арга зүй. 2001 он УБ. 35-36х,*
15. *Нарантуяа.Т Шинжлэх ухааны судалгааны арга зүй. 2013. УБ. 99, 111, 122, 127х*
16. *Чимэдсүрэн.О, Хандмаа.С, Мандухай.Г Чанарын судалгаа. Гарын авлага 2015 он УБ. 65х*
17. *Гэлэгжамц.С, Мөнхжаргал.Д Судалгааны арга зүйг хичээлийн гарын авлага 2016 он УБ. 98, 99, 102, 105, 115х*
18. *Сээсрэгдорж.С Анагаах ухааны дөрвөн үндэсийн язгуурын үндэс болон түүний тайлбар зохиолуудад хийсэн дүн шинжлэл: Анагаах ухааны боловсролын доктор (PhD) -ын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2002*
19. *Ганбаяр. Я Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс зохиолын судалгаа: Анагаах ухааны докторын (PhD) зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. Улаанбаатар. 2009*
20. *Чагданхорлоо Х. Эмийн түүхий эд судалд монголчуудын оруулсан хувь нэмрийг харьцуулан судалсан зарим үр дүн: АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2016.*
21. *Авирмэд С. Гүн Гомбожавын «Эмийн нэршлийн төвөд, хятад хэлний хадмал оршвой» зохиолын харьцуулсан судалгаа: АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2014.*
22. *Алтанчулуу Д. Үзэсгэлэнт нүдэн чимэг зохиолын модон эмийн аймгийг харьцуулан судласан нь: АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2016*
23. *Б. Отгончимэг, Ю. Галмандах, Х. Солонго ба бусад. Уламжлалт анагаах ухааны тооны нэрийн бэлгэдэл зүй. Улаанбаатар. 2019*

Analyzing the published terminology of Mongolian traditional medicine

Gereltsogt[1], Amar-Amgalan B[1], Byambaa E[1], Daariimaa B[1], Tumentsetseg U[1], Tserenchimed B[1], Enkhsaikhan U[1], Dagvatseren B[2], Tserentsoo B[2]

[1]International School of Mongolian Medicine, MNUMS
[2]Department of Traditional Prescriptionology, International School of Mongolian Medicine, MNUMS
E-mail: tserentsoo@mnums.edu.mn, Tel: +976-99242596

Background: In the process of social development, language is always refined, otherwise it will not be able to fulfill its social role as a tool of human communication. As human knowledge expands, new terms are created. Terminology plays an important role in any field of research and branch of science, and it is a challenge to research, sample, explain, and translate traditional medical terms into internationally recognized terms. The topic of this study was selected in order to analyze and compare the differences in terms of journals published in the field of Mongolian traditional medicine, and to serve as the basis for the standardization of terms.
Aim: Analyzing and comparing the published terminology of Mongolian traditional medicine.
Materials and Methods: This research were conducted at the ISMM, MNUMS and Innovate and Engineering center of the Inner Mongolia International Mongolian Hospital. “Mongolian Medicine Hospital” published by the International School of Mongolian Medicine, “Scientific Cognitive Oriental Traditional Medicine”, Health Protection Chamber of the Inner Mongolia Autonomous Region, Mongolian Medical Hospital Research Institute, Khokh City International Mongolian Medical Committee is a journal with a special issue of Mongolian medicine, and these journals were selected as the main research materials.
Results: There were a total of 1577 research articles in the 2008-2014 period of the Mongolian Medical Journal. Pharmaceutical prescription composition research 217 (13.7%) Pharmaceutical raw material research 55 (3.48%) Pharmaceutical composition research 83 (5.26) Mongolian pharmaceutical research 170 (10.77%) Theoretical research 113 (7.16) Women’s Disease treatment research 70 (4.43%) Remedial treatment 97 (6.15%) Illness sanatorium and nursing research 95 (6%) Joint disease treatment research accounts for 76(4.8%). Comparing the use of professional vocabulary in Mongolian Traditional Medicine terms, it is unique that menopausal syndrome is termed as period disease, cervical ulcer disease is termed as pelvic pain, habitual miscarriage is termed as habitual miscarriage, and infertility is termed as future non-pregnancy disease. Lumbar herniated intervertebral disc is also called lumbar herniated disc.
Conclusions: By analyzing the published theory, treatment, diagnostic methods, disease diagnosis and medicinal raw material terms of Mongolian Traditional Medicine, and comparing the use of vocabulary in traditional medicine terms, Mongolian traditional medical disease theory, diagnosis and treatment methods have their own characteristics. The terms of medicinal raw materials of plant, animal and mineral origin are written by Tibetan name in the composition of the prescription, and because some medicinal raw materials are used as substitutes, they are written quite differently.

Keywords: Alignment of Traditional Medicine Terminology and Vocabulary